



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Элсэлтийн хяналтын тоо батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2023-2024 оны хичээлийн жилд элсүүлэх бакалавр оюутны элсэлтийн хяналтын тоог хавсралтаар баталсугай.
2. Хяналтын тоонд багтаан, элсэлтийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал /Т.Намнан/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТТОГТОХ



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ тогтоох тухай

Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.4 дугаар заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дугаар заалт, Удирдах зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн бакалаврын сургалтад суралцагчийн нэг кредитийн үнэлгээг хавсралтаар тогтоон мөрдсүгэй.

2. Дархан-Уул аймаг дахь технологийн сургуулийн (1+3) хамтарсан хөтөлбөрт суралцагчийн нэг кредитийн үнэлгээг тухайн хөтөлбөрийг харьяалах бүрэлдэхүүн сургуулиудын нэг кредитийн үнэлгээгээр тогтоон мөрдсүгэй.

3. Магистрантурын сургалтын нэг кредитийн үнэлгээг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.4 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

4. Докторантурын сургалтын нэг кредитийн үнэлгээг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.9 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

5. Бизнесийн ахисан түвшний сургуулийн нэг кредитийн үнэлгээг Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийн бакалаврын нэг кредитийн үнэлгээг магистрантурт 1.4 коэффициентоор, докторантурт 1.9 коэффициентоор, Инженерийн ахисан түвшний сургууль, Нээлттэй боловсролын төвийн сургалтын нэг кредитийн үнэлгээг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн дундаж үнэлгээг магистрантурт 1.4, докторантурт 1.9 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

6. Цагийн сургалтаар элсэн суралцаж буй оюутны сургалтын нэг кредитийн үнэлгээг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.2 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

7. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд хэрэгжүүлж буй гадаадын их, дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийн хүрээнд гадаад хэл дээр заагдаж буй хичээлийн нэг кредитийн үнэлгээг тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг 2.0 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

8. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд суралцах гадаад оюутны сургалтын нэг кредитийн үнэлгээг тооцохдоо энэхүү тогтоолын 1-6 дахь заалтуудад дурдсан сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.2 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

9. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Коосен технологийн коллежийн 2023-2024 оны хичээлийн жилд шинээр элсэгч оюутны төлбөрийг 4,500.000 (дөрвөн сая таван зуун мянга), өмнөх хичээлийн жилүүдэд элссэн оюутны сургалтын төлбөрийг 3,800.000 (гурван сая найман зуун мянга) төгрөгөөр, ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын сургуулийн Ахлах сургуульд 2023-2024 оны хичээлийн жилд шинэ элссэн суралцагчийн сургалтын төлбөрийг 4,500.000 (дөрвөн сая таван зуун мянга), өмнөх хичээлийн жилүүдэд элссэн суралцагчийн сургалтын төлбөрийг 3,450.000 (гурван сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгөөр, Дархан-Уул аймаг дахь Ерөнхий боловсролын Ахлах сургуулийн сургалтын төлбөрийг 3,000.000 (гурван сая) төгрөгөөр тус тус тогтоон мөрдсүгэй.

ДАРГА



Д.БАТТОГТОХ

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 19 -ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт



ШУТИС-ИЙН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД МӨРДӨХ СУРГАЛТЫН НЭГ КРЕДИТИЙН ҮНЭЛГЭЭ

Д.Д	СУРГУУЛЬ	Хөтөлбөрийн ангилал	Нэг кредитийн үнэлгээ, төгрөгөөр		
			2023/24 оны хичээлийн жилд элссэн оюутан	2022/23 оны хичээлийн жилд элссэн оюутан	2019/20, 2020/21, 2021/22 оны хичээлийн жилүүдэд элссэн оюутан
1	Барилга, архитектурын сургууль	Инженер, технологи	157,274	146,711	111,675
2	Геологи, уул уурхайн сургууль		157,274	146,711	111,675
3	Механик, тээврийн сургууль		157,274	146,711	111,675
4	Мэдээлэл холбооны технологийн сургууль		157,274	146,711	111,675
5	Үйлдвэрлэлийн технологийн сургууль		157,274	146,711	111,675
6	Эрчим хүчний сургууль		157,274	146,711	111,675
7	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	Нийгмийн ухаан	153,810	143,479	109,215
8	Гадаад хэлний сургууль	Хэрэглээний шинжлэх ухаан	137,355	128,130	97,530
9	Дархан-уул аймаг дахь технологийн сургууль		129,640	92,147	92,147
10	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль		137,355	128,130	97,530
	ДУНДАЖ		131,347		